

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**СОЦИАЛИСТ ЧИГ БАРИМЖААТ ОРНУУД ДАХЬ
УЛСЫН СЕКТОРЫН ШИНЖ ТӨЛӨВ****Ц. Баатар**

Орчин үед социалист чиг баримжаа бүхий орнуудад капиталист биш хөгжлийн үйл явцад нөлөөлөх бүтцийн шинж чанар бүхий нийгмийн томоохон өөрчлөлт гарах болов. Энэ өөрчлөлт нь нийгмийн суурийг ч, давхрагыг ч хамрах болжээ. Тухайлбал эдгээр орнуудын эдийн засгийн үндэс нь улс ардын аж ахуй дахь улсын сектор болж байна.

Хөгжиж байгаа орнуудын эдийн засагт улсын сектор чухал үр нөлөөтэй байна. Улсын секторын нийгэм эдийн засгийн мөн чанарыг нээн үзүүлэх судалгааны арга зүйн ерөнхий үндэс нь марксист-ленинист эдийн засгийн онол, төр ангийн мөн чанарын тухай сургаал юм.¹

Социалист чиг баримжаат орнууд эдийн засгийн талаар биеэ даасан байхын тулд хувьсгалт ардчилсан төрийн удирдлагын дор материал, санхүү, хөдөлмөрийн нөөцийг улсын секторт төвлөрүүлж, нийгэм-эдийн засгийн хоцрогдлоо түүхэн ахар богино хугацаанд арилгач зорилт тавьж байна.

Өгүүлэн буй орнуудад үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэмчлэх гол арга болсон улсын секторыг байгуулж өргөжүүлэх улс төрийн зорилтыг засгийн эрх баригч нам хэрэгжүүлж байна. ЗХУКН-ын XXIV их хурал социалист чиг баримжаат орны улсын секторыг «мөн чанартаа хувьсгалт ардчилсан бодлогын эдийн засгийн бааз»² гэж тодорхойлжээ.

Социалист чиг баримжаат орнууд ангийн хурц тэмцлийн дунд улс орныхоо хөгжлийн түвшин, эдийн засагт гадаадын капиталын нөлөөний хэр хэмжээ, эдийн засгийн суурийн онцлогуудыг харгалзан өмчийн харилцааны хүрээнд шинэчлэлтийг явуулж нэгэнт эхлээд байна.

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. В. Андропов өмчийн харилцааны энэхүү нарийн төвөгтэй зорилтыг шийдвэрлэх нь тун амаргүй болохыг бодит социализмын түүхэн туршлага харуулж байгааг онцлон тэмдэглэж, «өмчийн харилцаанд эргэлт хийх нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг нийт ард түмний хүртээл болгочихдог ганц удаагийн үйл ажиллагаа биш»³ гэж бичжээ. Энэ асуудал социалист чиг баримжаат орны нийгэм эдийн засгийн дэвшилд мөн нэгэн адил хамаарах юм.

Социалист чиг баримжаат орнуудын нийгмийн дэвшлийн гарааны энэхүү эгзэгтэй үйл явцыг аль болох хурдан хугацаанд нааштайгаар шийдвэрлэхийн үүднээс хөгжлийн капиталист биш замаар нэгэнт замнасан улс орнуудын хуримтлуулсан түүхэн туршлагатай харьцуулан судлах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

¹ К. Маркс. Ф. Энгельс. Соч. т. 21. с. 310. т. 23, с. 761. Ленин В. И. Полн. собр. соч т. 3, с. 75-76, т. 34, с. 193—194.

² XXIV съезд Коммунистической Партии Советского Союза стенографический отчет. т. 1, с. 41.

³ Ю. В. Андропов. Карл Марксын сургаал, ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал. УБ.. 1983, 8-9-р тал

Шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын дэвшилд улсын сектор, хоршооллын хөдөлгөөн болон боловсон хүчний гүйцэтгэх үүрэг зэрэг асуудлаар БНМАУ тогтоолын төсөл удаа дараа боловсруулан НҮБ, түүний салбар байгууллагын хурал чуулганаар хэлэлцүүлэн батлуулж байв. 1981 онд хуралдсан НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын ээлжит XXXVII чуулганаас гаргасан илтгэлд БНМАУ болон бүсийн зарим орноос хоршооллын хөдөлгөөн, үндэсний мэргэжилтэй боловсон хүчин, улсын секторын асуудлаар явуулж байгаа бодлого, олсон туршлага, тавьж байгаа зорилт зэргийг нилээд тодорхой тусгасан нь⁴ өгүүлэн буй орнуудын улсын секторын өсөлт бэхжилтэнд манай туршлага хичнээн чухал ач холбогдолтой болохыг давхар нотолж байна.

БНМАУ-ын капиталист биш хөгжлийн замын олон улсын түүхэн ач холбогдлыг өрнөдийн зарим эрдэмтэд хүлээн зөвшөөрч байгааг хэлэх хэрэгтэй. Америкийн нэрт эрдэмтэн, профессор О. Латимор «Монголын тухай тэмдэглэл» гэдэг өгүүлэлдээ: «Монголчууд их зүйлийг хийжээ. Энэ нь өнөөдөр монголыг олон улсын хэмжээний ач холбогдолтой болгож байна.»⁵ гэжээ.

Социалист чиг баримжаат орнуудын улсын секторын нийгэм-эдийн засгийн мөн чанарыг тайлбарлах нь шинээр тавигдаж байгаа асар өргөн цар хүрээтэй нийлмэл асуудал юм.

Социалист чиг баримжаат орнууд дахь улсын секторын нийгэм-эдийн засгийн мөн чанар нь төрөөс орон нутгийн болон гадаадын капиталд яаж хандаж байгаагаар тодорхойлогдож байна.

Хувьсгалт ардчилсан төрийн үед улсын сектор нь гадаадын капиталтай хийх тэмцлийн хэрэгсэл болж үндэсний эдийн засгийг бататган хөгжүүлэхэд тулгуур болдгийг дээрх орнуудын туршлага харуулж байна.

Эдгээр оронд капиталист биш өөрчлөлт хийж байгаа нийгэм-эдийн засгийн суурь нь олон хэвшилт эдийн засаг бөгөөд хэвшил бүр нь өөрийн бяцхан үйлдвэрлэх хүчин, үйлдвэрлэлийн харилцаанаас тогтон тус тусын хөгжлийн өвөрмөц үедээ явж байна. Энэхүү олон хэвшлийн гүйцэтгэж байгаа үүрэг, хэтийн төлөв нь харилцан адилгүй бөгөөд үүнээс шалтгаалан капиталист биш хөгжлийг хангах зорилго улс орны эдийн засгийн тусгаар тогтнолын эрх ашгийн үүднээс эдгээр хэвшил тус бүртэй харьцах чиглэл боловсрон гарч байна. Эдгээр хэвшлүүдээс үндэсний олон хэвшилт аж ахуй бүрэлдэж хэвшлүүдийн хоорондох янз бүрийн харилцаа бий болж байна. Иймээс капиталист биш хөгжлийн үеийн эдийн засгийн чухал шинж нь олон хэвшилт аж ахуйн оршин тогтнож, улмаар капиталист биш хөгжлийн зонхиллыг бий болгон, эцэстээ тэрхүү хэвшлийн дангаар хөгжих нөхцлийг хангах явц мөн.

Социалист чиг баримжаатай орнуудын зонхилох хэсэг нь колоничлолын уршгаар дорой хөгжсөн үйлдвэрлэх хүч, нийгмийн харилцааг өвлөн авч байна. Аж үйлдвэр эхлэлтийн байдалтай буюу ерөөсөө байхгүй байна. Эдийн засгийн үндсэн салбарт феодал, хүй нэгдлийн газар эзэмшил, газар ашиглалт зонхилж байна. Ийм ч учраас Бирм, Танзани, Гвиней, Мадагаскар, Мозамбик, Бенин зэрэг орнуудын засгийн эрх баригчдын гаргасан тунхаглал болон намын программчилсан баримт бичгүүдэд улсын секторыг хөгжүүлэх нэг шалтгаан нь нэг талаас эдийн засгийн хоцрогдол, нөгөө талаас эдгээр орнуудын бие даан хөгжих шаардлага гэж заасан нь бүрэн үндэстэй юм.

⁴ «Үнэн» 1981 оны 6-р сарын 25. № 72.

“New York Times” 25, January 1974.

Эдийн засгаа өөд татах, нийгмийн дэвшлийг хурдасгах зайлшгүй шаардлагын үүднээс улс орондоо үүсгэн хөгжүүлж байгаа улсын сектор нь «ирээдүйн социализм байгуулах объектив субъектив урьдчилсан нөхцөлийг бий болгодог»⁶ байна.

Улсын секторын хувьсгалт ардчилсан мөн чанар нь улсын өмчийг аажмаар социализм байгуулах техник-эдийн засгийн бодит урьдчилсан нөхцөл болгодогт оршиж байна.⁷ Нэг талаар капиталист хэвшил ба бусад элементүүд, нөгөө талаар төлөвлөгөөт үйлдвэрлэлтэй хосолж ихэнхи тохиолдолд шилжилтийн системийн мөн чанарыг өөртөө агуулдаг⁸ байна.

Хөгжиж байгаа орны үндэсний дэвшилт хүчний дотор улсын капиталист секторыг хөгжүүлэн эдийн засгийн хоцрогдлыг арилгах найдвар тавих хандлага байгаа бөгөөд ийм алхам нь өнгөрсөнтэй харьцуулахад үйлдвэрлэлийн зарим нэг салбарт ахиц гаргасан боловч хэтийн зорилго болон нэгэнт тулгарсан олон талын асуудлыг шийдвэрлэх бололцоог хангахгүй байна. Улсын сектор ийнхүү капиталист чиглэлээр хөгжиж байхдаа улсын социалист сектортой зүйрлэхэд маш хязгаарлагдмал бөгөөд нэмүү өртгийн мөлжлөгөө хадгалдаг боловч гагцхүү өртгийн хуулийн шууд хараанаас (үйлчилгээнээс) чөлөөтэй нэлээд өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг хийгээд улсын капиталыг нөхөн үйлдвэрлэдэг талаас нийгмийн үйлдвэрлэлийн шинжтэй юм. Энэ нь капиталист хувийн үйлдвэрийн бие даан хөгжих чадвар алдагдаж, улсын секторыг түших болсон капитализмын ерөнхий хямралын тодорхой илрэл юм. Бага хөгжилтэй орнуудын эдийн засаг дахь улсын сектор нь бүхэлдээ империализм, шинэ колоничлолыг эсэргүүцсэн шинжтэй бөгөөд хувийн капиталаас үлэмж дэвшилттэй төдийгүй түүнтэй гүн гүнзгий зөрчилтэй хөгжиж байгаа эдийн засгийн шинэ үзэгдэл юм.⁹

Улсын сектор хөгжлийн капиталист, социалист хоёр хандлагыг агуулсан шинжээрээ давхар онцлогтой байна.

Шинэ тулгар орнуудын хөгжлийн төлөвтэй холбож үзэхэд эдийн засгийн улсын сектор голлох болсон нь эдгээр орны хөгжлийн чиглэл социализм тийш ойртож байгаа бас нэг баталгаа гэж үзэх үндэстэй юм.

Дээрх байдлаас үзэхэд улсын сектор нь тухайн улс орны нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжлийн хандлагаас ихээхэн шалтгаалдаг нь тодорхой байна. Тухайлбал үндэсний эдийн засгаа хөгжүүлэх тухайн ангийн өмчийн сонирхол, холбоотноо сонгох сонирхол, улсын өмчийг нөхөн үйлдвэрлэлээ өргөтгөхөд ашиглаж байгаа байдал, түүний эдийн засгийн харилцаа зэргээс хамаардаг байна. Энэ бүх хүчин зүйлийн нөлөөлөл нь улсын секторын хөгжлийн хурдац, далайц, зорилгын үндсэн чиглэлийг тодорхойлж байна. Ихэнхи тохиолдолд хөгжиж байгаа улс орнууд империалист колонийн ноёрхлын үед байсан эдийн засгийн хоцрогдсон бүтцийг өөрчилөхөд улсын секторт түшиглэж байгаа нь ангийн тэмцлийн явцад капиталист биш замын улс төр, эдийн засаг, үзэл суртлын нөхцлийг бүрдүүлж байна.

⁶ Зарубежный Восток и современность. т. 1, М. 1974. с. 198.

⁷ Некапиталистический путь развития стран Африки. М., 1967. с. 267. Государство социалистической ориентации. М., 1975. с. 54—55. Государственный сектор и социально-экономический прогресс в развивающихся странах. К. 1980. с. 13.

⁸ Колесов А. П. Государственный сектор экономики развивающихся стран с. 148.

⁹ Н. Дангаасүрэн. «Гуравдахь ертөнц» Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал», УБ., 1977. 19-р тал.

Ийнхүү социалист чиг баримжаатай орнууд дахь улсын сектор нь орчин үед «ирээдүйн социалист нийгмийн үйлдвэрлэлийн харилцааны цөм»-ийг¹⁰ өөртөө агуулж байна. Ингэснээрээ улсын өмч нь «нийт ард түмний өмчийн»¹¹ хэлбэрт ойртож байна. Онолын дээрх санал дүгнэлтүүд практикт хэрэгжих үндсэн шалгуур нь «Социалист шинжтэй гол хэвшлийг хөгжүүлэхэд одоо байгаа олон хэвшлийг захируулах социалист шинжтэй хэвшлийн ялалтыг хангах нийгэм-эдийн засгийн нөхцөл бүрдүүлэх явдал юм»¹²

Эцсийн бүлэгт социалист чиг баримжаат орнуудын улсын секторын өсөлт бэхжилт нь тухайн орны хувьсгалт ардчилсан төр үйл ажиллагаандаа шинжлэх ухааны социализмыг хэр зэрэг хэрэгжүүлснээс ихээхэн шалтгаалах билээ.

Социалист чиг баримжаат орнуудын төр нь эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч болж, улс орны нийгэм-улс төр, үзэл суртлын салбарыг хөгжүүлэх явцад идэвхтэй оролцож байна. Гэвч дээрх орнуудын нам төрийн үйл ажиллагааны онолын үндэс нь нийтдээ шинжлэх ухааны социализм хараахан болоогүй байна.

Социалист чиг баримжаа сонгон авснаа зарласан Бирм, Ирак, Сири зэрэг орнуудад империализмыг эсэргүүцсэн үндэсний хувьсгалт ардчилсан хүч засгийн эрхийг барьж байна. Танзани, Алжир, Мадагаскар зэрэг орнуудын хувьсгалт ардчилсан хүчин улс орондоо нийгэм-эдийн засгийн өөрчлөлт хийхдээ марксизм-ленинизмын онолыг нэлээд хэмжээгээр мөрдлөг болгож байна.

Социалист чиг баримжаат хэсэг орон ажилчин тариачны төрийн хэв маягийн эхлэл болох үндэсний ардчилсан төрөөс ардын ардчилсан төрийн хэв маягт урган орж байна. Эдгээр орны хувьсгалт ардчилсан удирдлага марксизм-ленинизмын байр суурин дээр баттай зогсож хувьсгалт өөрчлөн байгуулалт хийхдээ империализм, капитализмын эсэргүүцсэн тэмцлийн далайцыг аль болох хүчтэй болгож богино хугацаанд дорвитой амжилт олж байна. Эдгээрт Афганистан, Кампучи, Конго, Йемен (Өмнөд), Ангол, Мозанбик, Этиопи, Бенин зэрэг орон орж байна.

Афганистаны Хувьсгалт Зөвлөлөөс 1980 оны 4-р сарын 14-нд баталж тунхагласан «БНААфгУ-ын үндсэн зарчим»-д зааснаар Афганистаны Ардын Ардчилсан Намын жанжин шугам нь Афганистанд хүн хүнээ дарлаж мөлжих ёсгүй, шударга шинэ нийгэм байгуулах явдал гэж үзжээ.

1981 оны 5-р сарын сүүлчээр хуралдсан Кампучийн Ардын Хувьсгалт Намын IV их хурлын тогтоолд улс орныг социализмын замаар цаашид удирдах гол хүч марксист-ленинист намыг бэхжүүлэх, намаас ойрын ирээдүйд хэрэгжүүлэх бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж «Нам ард түмэнд хамгийн гол зүйл бол үндэсний тусгаар тогтнолыг найдвартай хамгаалах хөгжлийн социалист замд шилжих нөхцөл бий болгох явдал мөн»¹³ гэж заажээ.

1978 оны 10-р сард баталсан Йемений социалист намын программд 1968 онд тусгаар тогтнолоо тунхагласнаас хойших төрийн хувьслыг тодорхойлжээ. Түүнд, үндэсний тусгаар тогтнолоо байлдан олсны дараах хувьсгалт ардчилсан төр, дотоод гадаадын харгис хүчний эсрэг тэм-

¹⁰ Функция государства в независимых странах Африки. М., 1972. с. 126.

¹¹ Право в независимых странах Африки. М., 1969. с. 86.

¹² Ан. А. Громыко. Африка: прогресс, трудности, перспективы. М., 1981. с. 77.

¹³ «Үнэн», 1981 оны 12-р сарын 8.

цэл явуулахдаа нийгэм улс төрийн янз бүрийн хүчний холбоонд түшиглэсэн байна. Хувьсгалын цаашдын өрнөлт ангийн хүчний өсөлт нь ардын ардчилсан төрийн эхлэлийг тавьсан байна. Тус нам цаашдынхаа зорилтыг тодорхойлж үндэсний ардчилсан хувьсгалын зорилтыг хэрэгжүүлж социализмд аажмаар орох материал техникийн болон оюун санааны урьдчилсан нөхцөл бүрдүүлэх өөрчлөн байгуулалт хийхээр заажээ.¹⁴ Этиопийн нам, төрийн программд марксизм-ленинизмийг удирдлага болгон социалист чиг баримжааг баримтлан ардчилсан хувьсгалын зорилтыг тууштай хэрэгжүүлнэ гэж заажээ.¹⁵ Конгийн хөдөлмөрийн намын баримт бичигт Конгийн хувьсгал үндэсний ардчилсан шатандаа ороод байна. Цаашдын дэвшлийг хангах нөхцлийг энэ үед бүрдүүлэх болно»¹⁶ гэжээ.

Ийнхүү социалист чиг баримжаат орнуудын хөгжлийн процесс нь тухайн орны нөхцлөөс шалтгаалан янз бүрийн шатанд оршиж хувьсгалт өөрчлөн байгуулалт нь тус тусын өвөрмөц байдлаар явагдаж байна. Өгүүлэн буй орнуудын хэрэгжүүлж байгаа хувьсгалт ардчилсан төр нь В. И. Лениний зааснаар «энэ бол социализм хараахан биш боловч бас капитализм биш социализм өөд чиглэсэн асар том алхам»¹⁷ юм.

Социалист чиг баримжаат орнуудад гадаадын болон өөрийн орны томоохон капиталын үйлдвэрийн газрыг улсын болгох замаар мөн улсаас хөрөнгө оруулах, улсын үйлдвэрийн газрыг барьж байгуулах замаар улсын сектор байгуулж байна. Ингэхдээ ихэвчлэн социалист орнуудын тусламж дэмжлэгт тулгуурлаж, өөрийн орны эдийн засгийг хараат биш болгохын төлөө идэвхтэй тэмцэж байгаа нь империализм, шинэ колоничлолын эсрэг чиглэж, эдийн засгийн тусгаар тогтнолыг бэхжүүлэхийн төлөө тэмцэлд нь гол тулгуур болж байна. Тухайлбал 80-аад оны эх гэхэд л ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас хөгжиж байгаа орнуудад улсын сектороо бэхжүүлэх, байгалийн баялгаа эзэмших, үндэсний боловсон хүчин бэлтгэх явдлыг өргөтгөх үүднээс олгосон эдийн засаг-техникийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хэмжээ нийт дүнгээрээ барагцаалбал 42 млрд рубльд хүрчээ.¹⁸

Тусламжийн хөрөнгөөр ашиглалтанд орсон үйлдвэрийн хүчин чадал байнга өсөн нэмэгдэж байна. Одоо дээрх тусламжийн хэмжээ улсын секторт 40 гаруй хувийг эзлэх болов.¹⁹ Жишээлбэл, ган хайлуулалт жилд 30 сая тонн, нефть олборлолт 70 сая тонн, нефть боловсруулалт 30 сая тонн, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 16 сая квт-д хүрсэн байна.²⁰ Зөвхөн ЗХУ гэхэд л Сирид нийт цахилгаан эрчим хүчний 70 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа АС-СУАР-ын усан цахилгаан станцын цогцолбор, Алжирт нийт хүчин чадал нь 2 сая тонн ган хайлдаг болтол нэмэгдүүлсэн төмөрлөгийн заводын 2-р ээлж, Гвинейд 2,5 сая тонн боксит олборлох үйлдвэрийг байгуулсан байна.²¹ Энэ бүх тусламж нь социалист чиг баримжаат орнуудын улсын секторт зайлшгүй чухал шаардлагатай нөхцлийг хангах, үйлдвэрлэлийн потенциалыг оновчтой бөгөөд үр ашигтай байлгах, түүний бүтцийг боловсронгуй болгох боломж бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Ингэснээр дээрх орнуудын улсын секторыг улам бүр давамгайлах чиглэлээр бэхжүүлэ-

¹⁴ Азия и Африка сегодня. 1979. № 1. с. 19.

¹⁵ Проблемы мира и социализма. 1978. № 1. с. 40.

¹⁶ Там же. с. 44

¹⁷ В. И. Ленин. Полн собр. соч. т, 31. с. 133.

¹⁸ Мировая экономика и международные отношения. 1981. № 2. с. 8.

¹⁹ «Финансы СССР» 1982. № 3. с. 57.

²⁰ Мировая экономика и международные отношения. 1981. № 4. с. 56.

²¹ ЗХУКН-ын Төв Хорооны тайлан намын дотоод гадаад бодлогын ээлжит зорилт. УБ., 1981. 20-р тал.

хэд санхүүгийн болон хөдөлмөр, материалын дотоод нөөц, түүний хангамжийг туйлын үр ашигтай дайчлахад гол үүрэг гүйцэтгэх болжээ.

Улсын сектор нь үндэсний эдийн засгийн бие даасан цогцсыг бүрэлдүүлэн түүний салшгүй хэсэг болох орчин үеийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр холбоо, худалдаа, санхүү, шинжлэх ухаан боловсролын салбарыг нэгдсэн төлөвлөгөөгөөр хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд гол хөшүүрэг болж байна.

Академич Е. Примаков, улсын секторын бүтэц түүний мөн чанарт гарч байгаа хувьсал өөрчлөлтийг дүгнэж бичихдээ: «Социалист чиг баримжаат орны улсын секторын хувийн жингийн өөрчлөлт нь дэлхийн социализм, дэлхийн капитализмын хоорондох тэмцэл ба тэдгээрийн зэрэгцэн орших «гадаад орчны» нөлөөний дор явагдаж байна.²² гэжээ.

Социалист чиг баримжаат орнуудын эдийн засагт улсын сектор бүрэн бэхжих хүртэлх хугацаанд аж ахуйн уламжлалт салбарууд, түүний зэрэгцээ хувийн жижиг дунд хэмжээний үйлдвэр, худалдаа үйлчилгээний зэрэг салбарыг хэвээр үлдээж эдгээрийг хосолж байна. Улмаар эдийн засгийн талаар бие даах бодлогод гадаадын капиталыг ашиглах хэм хэмжээг тогтоох зэрэг капиталист биш хөгжлийн үеийн эдийн засгийн олон талтай арга хэмжээний явцаар аж үйлдвэржих хөрөнгө хуримтлалын эх булаг бий болгохын хамт хөдөлмөрчдийн аж амьдралын түвшинг байнга дээшлүүлэх зарчмыг хэрэгжүүлэх чиглэлд мэдэгдэхүйц ахиц олов.

Улсын секторын аж үйлдвэр байгуулах, өргөтгөхөд эрдэс эрчим хүчин, нутаг дэвсгэр, хүн амын нөөц, газарзүйн байдал зэрэг хүчин зүйлээс шалтгаална.

Гэвч нийгэм-эдийн засгийн нэн хоцрогдмол бүтэцтэй орнууд (халуун бүсийн Африк) энэ зорилтыг шийдвэрлэхэд удаан хугацаа орох төлөвтэй байна. Юуны өмнө хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүнийг бололцооны хэрээр шинэчилж хүн амын дийлэнхи олонх болсон тариачдын амьдралыг сайжруулахад эдгээр орны бодлого зүй ёсоор төвлөрч байна. Гэвч хөдөө аж ахуй зонхилж байхаа больж, хөгжлийн бодит шаардлага эдийн засгийн бодлогод аж үйлдвэрийн эзлэх байр суурийг өргөтгөж өгөх нь мэдээж, зөвхөн энэ үндсэн дээр л эдийн засгийн хурдан өсөлтийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжийг орчин үеийн түвшинд хүргэж, хүн амд ноогдох үндэсний орлогыг нэмэгдүүлж чадах билээ. «Чөлөөлөгдсөн олон оронд сүүлийн үед гарсан өөрчлөлтөнд ямар гол үндсэн чиглэл байна вэ? Энэ бол аж үйлдвэрийг хөгжүүлэхэд улсын секторт голчлон тулгуурласан. Феодалын газар эзэмшлийг устгасан, шинэ тулгар улсууд байгалийн нөөц баялгийг үр ашигтайгаар эрх мэдэлдээ оруулахын тулд гадаадын үйлдвэрүүдийг улсын болгосон, үндэсний боловсон хүчин бүрэлдэн бий болсон явдал юм. Өөрөөр хэлбэл дэлхийн энэ хэсэгт байгаа саад бэрхшээлийг сөрсөн гүн гүнзгий дэвшилт өөрчлөлт гарч байна. Энэ бол түүхэн үйл явц даруй мөн»²³ гэж ЗХУКН-ын XXV их хурал онцлон тэмдэглэсэн билээ.

Социалист чиг баримжаат орнууд улсын секторт тулгуурлаж үйлдвэржих үйл явцыг нэгэнт эхлээд байна. Гэвч үйлдвэржилт дөнгөж анхныхаа алхмыг хийсэн бөгөөд зөвхөн хуримтлалын фондын хязгаарлагдмал байдал төдийгүй дотоод зах зээлийн явцуу байдал, үндэсний мэргэжилтэй боловсон хүчний бэлтгэл, соёлын хөгжилтийн доогуур түвшин зэргээс бий болсон олон янзын бэрхшээлтэй тулгарч байна.

²² «Мировая экономика и международные отношения» 1981. № 7. с. 11.

²³ «ЗХУКН-ын Төв Хорооны тайлан. дотоод, гадаад бодлогын талаар тавих намын ээлжит зорилт» УБ., 1976. 17-р талд.

Эдгээр бэрхшээлийг даван туулахад үндэсний үйлдвэрлэх хүчний өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн үйл явцад шууд ба шууд бус бүхий л боломжтой арга хэмжээг төрөөс авч явуулж байна. Улсын секторыг бий болгох, нэмэгдүүлэх угтвар нөхцөл болох гадаадын болон орон нутгийн капиталыг тодорхой хүрээ хязгаарын дотор зохистойгоор ашиглах, улсын болгох, улсын секторын хүрээнд өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх, улсын төсвөөр дамжуулан нөөц хуримтлуулах зэрэг янз бүрийн замаар хэрэгждэг. Улсын секторыг бий болгох нэг арга бол гадаадын капиталыг улсын болгох явдал юм. Улс орны дотоодод гадаадын капиталын үзүүлэх нөлөөлөл болон түүний эдийн засгийн үндсийг устгаж, гадаадын монопольт өмчийг улсын болгох нь эдгээр орны эдийн засаг дахь улсын секторыг бэхжүүлэх гол хөшүүрэг мөн. Эдийн засгийн зонхилох салбар тухайлбал, том аж үйлдвэр, цахилгаан станц, тээвэр, холбоо, банк зэрэг үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг улсын болгосноор төр өөрийнхөө мэдэлд аж ахуйн хөгжилд нөлөөлөх чухал хөшүүргүүдтэй болж чаддагийг улс орнуудын хөгжлийн туршлага харуулж байна.

Алжирт нефтийн аж үйлдвэрийг улсын болгосон нь олон улсын нефтийн монопольт картельд оролцогчдод хүчтэй цохилт боллоо. Афганистан, Конго, Этиоп, Йемен зэрэг орнууд гадаадын өмчийг хураах, худалдан авах талаар нэлээд дорвитой алхмууд хийгдэж байна.

Өгүүлэн бүхий орнуудын эдийн засагт улсын секторын хувийн жин нэмэгдэж байна. Үндэсний орлогын үйлдвэрлэлд түүний эзлэх хувийн жин 30—50 хувийн хооронд хэлбэлзэж байна.²⁴

Улсын сектор нь үйлдвэрлэлийн нийгмийн шинжээрээ харьцангуй нэн өндөр түвшинд багтдаг хийгээд урсгал чанар бүхий хувийн аж ахуйг бодвол эдийн засагт хяналт тавих төвлөрсөн төлөвлөгөө, удирдлага зэрэг олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоог хангагдаараа үлэмж дэвшилтэд ач холбогдолтой юм.

Алжир нийгэм эдийн засгийн өөрчлөн байгуулалтдаа тодорхой ахиц гаргаснаар 1982 онд улсын сектор үндэсний орлогын 90 хувь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 60 хувийг гаргаж, нийт үйлдвэрлэлийн хүч чадлын 70 хувийг эзэлж байна. Этиопт улсын сектор нийт бүтээгдэхүүний 90 хувийг гаргаж, гадаад, дотоод худалдааны 60—70 хувьд нь улсын хяналт тогтоосон байна.²⁵ Сирид улсын сектор үйлдвэрлэлийн хүч чадлын 70 орчим хувь томоохон үйлдвэр байгууллагын дөрөвний гурав орчим хувийг улсын хяналтанд авсан байна. Бирмд улсын сектор үндэсний эдийн засагт 50 хувийг эзэлж байна.²⁶

Сири улс хөдөө аж ахуйн хөгжлөөр мөн дээгүүр байранд явж байна. Социалист чиг баримжаат орны төрийн зүгээс дотоод худалдаанд улсын хяналтыг хүчтэй болгох талаар нэлээд ахиц гэрч байна.

Үндэсний эдийн засгийн улсын секторыг бэхжүүлэхийн зэрэгцээ хувийн капиталист үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа зэрэгт ардын төрийн хяналт тогтоох замаар капиталист биш салбар болгон өөрчлөх дэс дараатай алхамд орж байна.

Дээрх байдлаас үзэхэд социалист чиг баримжаат орнуудын үндэсний эдийн засаг дахь улсын сектор нь империалист шинэ колоничлолын бодлогыг таслан зогсоох эдийн засгийн суурь дэвсгэрийн шинжтэй үүссэн бөгөөд төрийн үлэмжхэн дэмжлэгтэйгээр богино хугацаанд хүч

²⁴ Государственный сектор и социально-экономический прогресс в развивающихся странах. К., 1980. с. 23.

²⁵ «Үнэн», 1982 оны 5-р сарын 25. № 124.

²⁶ Государственный сектор и социально-экономический прогресс и развивающихся странах. К., 1980, с. 24.

чадал нь өсөн нэмэгдэж улс орны эдийн засагт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болж байгаад түүний нийгэм-эдийн засгийн мөн чанар оршино.

БНМАУ-д улсын сектор үүсч бий болсон үйл явцыг социалист чиг баримжааны орнуудтай харьцуулж үзэхэд нэлээд өвөрмөц онцлогтойгоор хэрэгжсэн байна.

Ю. Цэдэнбал энэ талаар дүгнэж бичихдээ: «Капиталист биш замаар социализмыг зорин хөгжсөн БНМАУ-ын хөгжлийн онцгой нэгэн шинж гэвэл социалист салбар нь юуны өмнө гүйлгээний салбарт эд хэрэглэгчдийн хоршоолол, улсын худалдаа, худалдаа-үйлдвэрийн банк, харилцаа холбоо, авто тээврийн газар зэрэг үйлдвэрийн бус хөдөлмөрийн хүрээнд байгуулагдаж эхэлсэн явдал мөн»²⁷ гэжээ.

Хувьсгалын анхны жилүүдэд ЗХУ-тай хувь нийлүүлэх үндсэн дээр байгуулсан харилцан туслах хоршоо нь тус оронд шинээр бүрэлдэн тогтож буй эдийн засгийн хэвшлийг төлөөлж байсан бөгөөд түүний үйл ажиллагааг улсын анхдугаар их хурлын тогтоолд «харилцан туслах хоршооны уул зорилго нь харъяат улсын түүхий эд зэргийг тухайн газар шууд хүргэж зарах, мөн харъяат улсын хэрэгцээт зүйлийг гадаад улсаас худалдан авч ирж олон ардуудад худалдах, түүхий эдийг боловсруулан үйлдэх газруудыг ... байгуулах»²⁸ гэж заажээ.

Түүнчлэн 1924 онд ЗХУ-тай хувь нийлүүлэх үндсэн дээр худалдаа аж үйлдвэрийн банк байгуулснаар байр сууриа бэхжүүлсэн улс орны санхүүгийн систем нь худалдааны байгууллагын системд аж үйлдвэрийн газрыг хөгжүүлэх явдлыг дэмжиж байв. Ийнхүү социалист аж ахуйн хэвшил монголын нөхцөлд ЗХУ-ын тусламжтайгаар эхлээд таваарын гүйлгээ, санхүү зээлийн системийн хүрээнд үүссэн бөгөөд түүний үйлчилгээгээр хожим нь материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд бий болсон байна.

Ардын хувьсгалын ялалтын дараахан бэлчээрийн эдэлбэр газрыг улсын болгосон нь газар өмчлөх явдлыг мөлжлөгийн зэвсэг болгон ашиглахад хаалт саад болов. Ингэснээр хөдөлмөрийн зүйл болсон мал хувийн эзэмшилд, хөдөлмөрийн зэвсэг болсон бэлчээрийн эдэлбэр газар нь улс нийтийн өмч болжээ. Энэ нь улсын секторыг үүсгэн бий болгох бас нэг хүчин зүйл болсон юм.

1924 оны наймдугаар сард хуралдсан МАХН-ын III их хурал хоцрогдсон орон капиталист биш замаар хөгжих бололцооны тухай В. И. Лениний сургаалыг үндэс болгон заахдаа: «Нам засгаас зөвхөн феодалын өмчийн эсрэг төдийгүй хувийн эрх мэдэлд үлэмжхэн хөрөнгө баялаг хуримтлахын эсрэг эрс шийдвэртэй тэмцэл явуулж, үйлдвэрлэлийн хэрэгслийн нийгмийн өмчид түшиглэсэн улс, хоршооллын аж ахуйг бий болгоно» гэжээ. МАХН-ын III их хурлын заалтыг үндэс болгож БНМАУ-ын анхдугаар их хурлын шийдвэрт «Монгол оронд ирээдүйтэй аж ахуйн хоёрдахь салбар бол аж үйлдвэр мөн»²⁹ гэж цохон тэмдэглэсэн байна.

Хувьсгал ялсны дараахан тус оронд аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх материал-техникийн бэлтгэл бааз байсангүй. Аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд байгалийн нөөц баялаг, эрчим хүчний эх үүсвэрийг судалж илрүүлэх, мал аж ахуйгаас гарах ашиг шимийг арвижуулан түүхий эд материалыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, аж үйлдвэрийн газар, салбаруудыг орчин үеийн техник тоноглолоор

²⁷ Ю. Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал УБ. 1976. 248 дахь тал.

²⁸ Улсын их хурлын сонин. 1925 он. 3-р дэвтэр, 124-р тал.

²⁹ Протокол 1 великого хурала МНР. Стенограмма. Улан-Батор. 1925. с. 230.

хангах, үйлдвэржүүлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох, мэргэжилтэй боловсон хүчин, ажилчдыг бэлтгэх зэрэг хойшлуулшгүй чухал бөгөөд нэрийн төвөгтэй асуудлуудыг ЗХУ-ын техник эдийн засгийн бүх талын тусламж, тус улсын эдийн засгийн үндэс болох мал аж ахуйн өрнөлт, улс хоршооллын худалдааны эргэлтийн өсөлтийн үндсэн дээр хөнгөн аж үйлдвэрийн салбарыг бий болгож эхэлсэн нь мөн чанартаа үйлдвэржих эхлэл байлаа. Энэ бол бусад аж үйлдвэр хөгжөөгүй олонхи орны үйлдвэржих үйл явцтай төстэй нийтлэг шинжтэй байна.

Хувьсгалын ардчилсан шатны газар тариалан, мал аж ахуйгаас ялгаран гарч богино хугацаанд хөдөө аж ахуйн шинэ том салбар болсонтой холбогдож түүний бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэрийн газрууд нэгэн зэрэг шинээр байгуулагдаж байлаа. Энэ утгаар газар тариалан, үйлдвэржих нэгэн үйл явц түүний ялгаран гарах өөр үйл явцтай зэрэг явагдаж байлаа гэж болох байна. Зөвхөн 30-аад оны эхэн үеэс БНМАУ-д орчин үеийн аж үйлдвэр байгуулж эхэлжээ.

В. И. Ленин «тухайн үед бүх гинжийг алдахгүйгээр барьж байх ба дараачийн гогцоонд шилжих бэлтгэлийг баттай хийхийн тулд бүх хүчээр барьж авбал зохих бэлтгэл гинжний тийм онцгой гогцоог олж авах хэрэгтэй. Тэгэхдээ үйл явдлын түүхэн гинжит гогцоонуудын дараалал, тэдгээрийн хэлбэр, бие биеэсээ ялгаатайгаар холбогдсон байдлаараа төмөрчний хийсэн энгийн гинж шиг тийм амар, тийм тэнэг биш юм»³⁰ гэж улс ардын аж ахуйн бүхий л систем ба түүний салбаруудын байр, хоорондын хэлхээ холбоо, ялгаа тэдгээрийн дотроос тухайн үед зохих салбарыг зөвөөр сонгон олж чадахын чухал болохыг гайхамшигтай уран тодорхойлжээ.

МАХН, В. И. Лениний энэ сургаалыг мөрдлөгө болгож улс орноо капиталист биш хөгжлийн замаар хөгжүүлэх явцдаа бүтээлчээр хэрэгжүүлснийг БНМАУ-ын түүхэн туршлага тодорхой харуулж байна.

Манай орны түүхэн туршлагаас үзэхэд капиталист биш хөгжлийн төлөө тэмцэлд төрийн эдийн засгийн үүргийг өндөрт байлгах, улсын секторын олон салбаруудыг бий болгон дэмжиж, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх хэрэгт олон түмний ухамсартай оролцоог өргөжүүлэх явдал онцгой чухал болох нь тодорхой байна. Энэ бол эдийн засгийн талаар буурай хөгжилтэй орнуудад үндэсний биеэ даасан аж ахуй байгуулах эхлэлт мөн бөгөөд нөгөө талаар капитализмыг алгасан социализмд шилжих өнөөгийн хувилбарууд нь хичнээн онцлог өвөрмөц талтай байлаа ч гэсэн нийтлэг шинжтэй болсныг социалист чиг баримжаат орнуудын хөгжлийн туршлага давхар нотолж байна.

Социалист чиг баримжаат орнуудын хөгжлийн өнөөгийн шатанд ийнхүү улсын секторын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэхийн хэрээр түүний хэлбэр, агуулга, үйлчилгээний хүрээ улам бүр өргөжин баяжсаар байна.

Олон улсын монополийн эсрэг явуулж буй тэмцлээ улам эрчимжүүлэх, бодит социализмтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа бүх талаар бэхжүүлэх явдал социалист чиг баримжаат орнуудын хөгжилт, тэдгээр орны улсын секторын бэхжилтэнд шийдвэрлэх нөхцөл болно.

³⁰ В. И. Ленин: Зохиолуудын 33-р боть. 29-р тал.

ГОСУДАРСТВЕННЫЙ СЕКТОР В СТРАНАХ СОЦИАЛИСТИЧЕСКОЙ ОРИЕНТАЦИИ.

(Р е з ю м е)

Государственный сектор в большинстве стран, освободившихся от колониального и империалистического господства, создает благоприятные условия для изменения структуры отсталой экономики, для политических и экономических реформ.

В странах социалистической ориентации госсектор создается путем национализации иностранных и национальных предприятий, финансированием и созданием государственной промышленности. Проводя экономические реформы, правительства этих стран опираются на всестороннюю помощь и сотрудничество с социалистическими странами. Дружба с социалистическими странами является залогом успешного, стабильного, поступательного развития экономики и упрочения независимости страны.

Помощь социалистических стран направлена на поддержание экономического потенциала страны на должном уровне, усовершенствование его структуры и эффективное его использование.

Госсектор способствует планомерному развитию промышленности, сельского хозяйства, транспорта, торговли и других отраслей национальной экономики.

Госсектор в развивающихся странах социалистической ориентации играет немаловажную роль в противодействии неоколониалистической политике империализма, способствует росту производительных сил и переходу к новым производственным отношениям.

При успешном завершении демократических преобразований в странах социалистической ориентации госсектор является тем базисом на основе которого можно осуществить социалистические преобразования.